


СҮРЬЕЭГИЙН МЭС ЗАСЛЫН БАГИЙГ БНСУ-Д МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛНЭ



Солонгосын Үндэсний Сүрьеэгийн Нийгэмлэгийн толоологчид 2017 оны есдүгээр сарын 5-ны одор ХОСҮТ-д зочиллоо. Эрүүл мэндийн яам, Халдварт овчин судлалын үндэсний тов, Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгүүд Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран 2016 оноос Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй сүрьеэгийн эсрэг Монгол-Солонгосын хамтын ажиллагаа тослийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Энэ удаа Солонгосын Үндэсний Сүрьеэгийн Нийгэмлэгийн толоологчид оргон бүрэлдэхвэнтэй ирж уг тослийн 2 дахь шатыг эхлүүлэх гэрээнд гарын үсэг зурах ёслолд оролцсон юм. Монгол Улсад хийгдсэн Хүн амын дундах сүрьеэгийн тархалтыг тогтоох судалгааны үр дүнгээс үзэхэд манай улсын хүн амын дундах уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн тархалт нь жил бүр бүртгэгддэг сүрьеэгийн тохиолдлоос 3 дахин ондор гарсан. жилд дунджаар 4000 гаруй сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдэж байна. Сүрьеэ нь Монголд бүртгэгдэж буй халдварт овчний шалтгаант овчлолийн гуравдугаарт, нас баралтын шалтгааны нэгдүгээрт бичигдэж байна.

Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй сүрьеэгийн эсрэг Монгол-Солонгосын хамтын ажиллагаа тослийг үйл ажиллагаа нь Нийслэлийн Чингэлтэй болон Баянзүрх дүүрэг, их сургуулийн оюутнуудын дунд сүрьеэ овчнийг илрүүлэх, оношлох чиглэлээр явуулын үзлэг шинжилгээг үнэ толбогвй, зорилтот хүн амын амьдарч, суралцаж буй газарт нь очиж хийж байгаа юм. Энэ тосол хэрэгжсэн жил гаруй хугацаанд Чингэлтэй дүүргийн 13000 гаруй иргэн, их сургуулийн 3000 гаруй оюутныг сүрьеэ овчнийг эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулан уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн 110 тохиолдол, үүнээс эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 10 тохиолдлыг илрүүлэн оношилж, эмчилгээнд хамруулсан байна. Энэ нь манай улсын хүн амын эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр болж байна. Онгорсон хугацаанд тослийн хүрээнд хийгдсэн ажлуудыг дүгнэн, үр дүнтэй байна гэж талууд үзэж байгаа учраас 2020 оныг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр санхүүжүүлэгч байгууллагууд шийдвэрлэж, гэрээнд гарын үсэг зурах хүндэтгэлийн арга хэмжээ очигдор болсон билээ.

Ийнхvv цаашид тослийн вйл ажиллагааг 2020 оныг хvртэл vргэлжлvвлэн хэрэгжvвлэхээр шийдвэрлэснээр энэ оны дунд veэс эхлэн нуруу нугасны сvрьеэгийн чиглэлээр тослийн вйл ажиллагааг оргожvвлэн, ХОСҮТ-ийн сvрьеэгийн мэс заслын багийг БНСУ-д мэргэжил дээшлvвлэх, шинэ технологи эзэмшvвлэх, мэс заслын тоног тохооромжийг дэлхий нийтийн жишигт нийцvвлэх, манай улсын сvрьеэтэй тэмцэх, сэргийлэх хотолборт ихээхэн тус дэм болохын зэрэгцээ, хvн амын эрvвл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулахад vнэтэй хувь нэмэр оруулах юм.

Солонгосын Үндэсний Сvрьеэгийн Нийгэмлэгийн толоологчдийг ХОСҮТ-ийн Халдварт овчин судлалын тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал Б.Цацралт-Од, Эмнэлгийн тусламж вйлчилгээ эрхэлсэн дэд захирал М.Тунсаг нар хvлээн авч уулзаж ХОСҮТ-ийн вйл ажиллагааны талаар танилцуулж, Улаанбаатар хотод хэрэгжvвлж буй сvрьеэгийн эсрэг Монгол-Солонгосын хамтын ажиллагаа□□ тослийн эхний шатны хэрэгжилтийн талаар мэдээлэл оглоо. Солонгосын Үндэсний Сvрьеэгийн Нийгэмлэгийн толоологчид ХОСҮТ-ийн Сvрьеэгийн тандалт судалгааны алба, Сvрьеэгийн клиник, Мэс заслын тасгуудаар орж вйл ажиллагаатай нь танилцлаа.